

Олон улсын тээвэрлэлтийн үйлчилгээ Сэдэв: Агаарын тээвэрлэлт


**Улаанбаатар хот
2018 он**

АГУУЛГА

1. Агаарын тээвэрлэлтийн онцлог, давуу болон сул талууд	3
2. Олон улсын агаарын тээвэрлэлтийн хэлбэрүүд	5
Байнгын тээвэрлэлт	5
Байнгын бус тээвэрлэлт	5
Нэмэлт тээвэрлэлт	5
Тусгай тээвэрлэлт	5
Түрээсийн тээвэрлэлт.....	6
3. Олон улсын агаарын тээвэрлэлтийн тариф.....	7
Үндсэн тариф	7
Ангиллын тариф	7
Тусгай тариф	8
4. Олон улсын агаарын тээвэрлэлтийн эрх зүйн зохицуулалт	10
Хүснэгт 1. Агаарын тээвэрлэсэн ачаа /тонн/.....	11
Хүснэгт 2. Олон улсын нистэгийн тоо	11
Ашигласан эх сурвалж	14

1. Агаарын тээвэрлэлтийн онцлог, давуу болон сул талууд

Олон улсын агаарын тээвэрлэлт гэдэг нь шилжүүлэн ачилт ба түр буулт хийж буй эсэхээс үл хамааран, нэг орны нутаг дэвсгэрт оршин буй ачилт хийх цэгээс нөгөө орны нутаг дэвсгэрт оршин буй буулгах цэгийн хооронд нисэх онгоцоор үйлдэж буй тээвэрлэлтийг хэлнэ.



Энэ төрлийн тээвэрлэлт нь богино хугацаанд үнэт болон түргэн хүргэх ачаа, хурдан мууддаг хүнсний зүйлс, цэцэг болон бусад барааг тээвэрлэхэд ашиглагдаж байна.

Агаарын тээвэрлэлтийн **давуу тал нь:**

- Өндөр үнэтэй, бага хэмжээний бараа тээвэрлэхэд тохиромжтой.
- Бараа бүтээгдэхүүнд ямар нэгэн эвдрэл гэмтэл гарах нөлөөлөл бага.
- Хурдан шуурхай.
- Дунд зэргийн эсвэл холын зайнд тээвэр хийхэд ашигтай.
- Ачаа барааны баглаа хялбар.

Сул тал нь:

- Их хэмжээний бүтээгдэхүүн тээвэрлэх боломжгүй, жин, хэмжээний хязгаартай.
- Зардал өндөр.
- Цаг агаарын нөлөө их.

- Нисэх онгоцны буудлууд ихэвчлэн үйлдвэрлэгчийн агуулахаас болон хүлээн авагчийн байршлаас хол байрладаг.

Агаарын тээврийн дээрх онцлогоос хамаараад дараах ачаа барааг ихэвчлэн тээвэрлэж байна. Үүнд:

1. Үнэт ачаа

- Алт, мөнгө зэрэг үнэт металл
- Мөнгөн дэвсгэрт, үнэт цаас
- Урлагийн бүтээл, музейн үзмэр
- Археологийн олдвор, түүхийн дурсгалт зүйлс
- Шинжлэх ухааны бүтээл, дээж, сорьц гэх мэт

2. Түргэн муудах ачаа

- Далайн бүтээгдэхүүн
- Амьд цэцэг, жимс гэх мэт

Экспортын үйлдвэрлэл эрхэлдэг үйлдвэрлэгчид энэ төрлийн тээврийн хэрэгслийг сонгохоор шийдсэн бол өөрийн үйлдвэрлэдэг бараа, түүний зах зээлийн үнэ, шинж чанарыг харгалзан шийдвэрээ гаргах нь зүйтэй. Учир нь бараа бүтээгдэхүүний үнэ зах зээлийн өрсөлдөөнд зайлшгүй анхаарах асуудлын нэг байсаар ирсэн бөгөөд бусад тээвэрлэлттэй харьцуулахад агаарын тээвэрлэлтийн зардал өндөр учраас таны бараа бүтээгдэхүүний зах зээлийн үнийг өсгөж, өрсөлдөх чадварыг бууруулах эрсдэлтэй болохыг харгалзаж үзэх нь зайлшгүй юм.

2. Олон улсын агаарын тээвэрлэлтийн хэлбэрүүд

Олон улсын агаарын тээвэрлэлтийг үйлдэж буй хэлбэрээр нь 2 ангилдаг.

Үүнд:

- Байнгын тээвэрлэлт
- Байнгын бус тээвэрлэлт

Байнгын тээвэрлэлт

Байнгын тээвэрлэлт гэдэг нь агаарын тээврийн сүлжээний талаар олон улсын хэмжээний хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрийн дагуу тогтоосон хуваариар, тодорхой чиглэлд үйлдэж буй тээвэрлэлтийг хэлнэ.

Тээвэрлэлт хийх нислэгийн хуваарьт замын маршрут, замд түр буудаллах цэгүүд, маршрутын цэгүүдэд буух хугацаа ба тэдгээр цэгүүдээс хөөрөх хугацаа, нислэг үргэлжлэх хугацаа, онгоцны төрөл зэргийг тусгадаг.

Нислэгийн хуваарьт хийх аливаа өөрчлөлтийг хэлэлцэн тохиролцогч орнуудын харилцан зөвшилцлын дагуу оруулдаг.

Байнгын бус тээвэрлэлт

Байнгын бус тээвэрлэлт гэдэг нь нислэгийг үйлдэх нэг удаагийн тусгай зөвшөөрлийн дагуу хийж буй тээвэрлэлт юм. Байнгын бус тээвэрлэлтийн доорх хэлбэрүүд байдаг. Үүнд:

Нэмэлт тээвэрлэлт

Агаарын тээврийн нэг удаагийн ачааны хэмжээнд хязгаартай байдаг тул нэмэлт тээвэрлэлтээр барааг нийлүүлэх шаардлага гардаг.

Энэ нь байнгын нислэг хийдэг агаарын шугамд цагийн тусгай хуваарийн дагуу хийж буй тээвэрлэлт юм. Ачааг агаарын байнгын тээвэрлэлтээр тээвэрлэх боломжгүй үед талуудын тохиролцоогоор нэмэлт тээвэрлэлтийг үйлдэнэ. Нэмэлт тээвэрлэлтийг ихэвчлэн байнгын тээвэрлэлт хийх өдөр, хуваарьт цагаас нь 24-өөс илүүгүй цагийн өмнө буюу хойно үйлддэг.

Тусгай тээвэрлэлт

Энэ нь байнгын тээвэрлэлтийн шугамаар эсвэл тусгайлан бэлтгэсэн маршрутын дагуу тусгай үүрэг даалгаврыг биелүүлэх зорилгоор үйлддэг. Жишээлбэл Монгол улс энхийг сахиулагчдаа гадаад улсад илгээхдээ тусгай

тээвэрлэлт хийж, цэргийн албан хаагчдаа болон тэдний зэвсэг техникийн хамт илгээх гэх мэт.

Түрээсийн тээвэрлэлт

Үүнийг тээвэрлэгч болон захиалагчийн хооронд байгуулсан тусгай гэрээний дагуу үйлдэнэ. Захиалагч нь тодорхой чиглэлд ачаа тээвэрлэх зорилгоор, тодорхой нөхцлийн үндсэн дээр онгоцыг бүхэлд нь түрээслэн ашиглах гэрээ байгуулдаг. Жишээлбэл, тухайн улс мөнгөн тэмдэгтээ гадаад улсад хэвлүүлдэг бол нэмэлт тээвэрлэлтээр хэвлүүлсэн мөнгөө татаж авах гэх мэт.

3. Олон улсын агаарын тээвэрлэлтийн тариф

Олон улсын агаарын тээврийн байнгын тээвэрлэлтэд зарласан ба зарлагдаагүй тарифыг хэрэглэдэг.

- **Зарласан тариф** бол агаарын ачаа тээврийн тарифын лавлахад нийтлүүлсэн, тээвэрлэлт эхлэх буудлаас хүрэх буудал хүртэл ачааг зөөвөрлөсний төлөө төлдөг татвар хураамж юм. Хэрэв хоёр орны буудлуудын хоорондох тээвэрт зарласан тарифыг хэрэглэж байгаа бол аливаа ачааг тээвэрлэхэд зөвхөн үүнийг л мөрдөнө.
- **Зарлагдаагүй тарифыг** агаарын тээврийн тухайн чиглэлд зарласан тариф байхгүй тохиолдолд ашигладаг.

Агаараар ачаа тээвэрлэх тариф нь зөвхөн тээвэрлэлт хийх эхний цэгээс, эцсийн цэг хүртлэх үйл ажиллагаатай холбоотой бөгөөд үүнийг тогтооход тээвэрлэх замын урт, ачаа тээвэрлүүлэх эрэлт, бусад төрлийн тээврийн байгууллагуудыг тогтоосон тариф, тухайн чиглэлийн тээвэрлэлтийн үйл ажиллагааны хэвийн ачаалал, тээвэрлэгч, тээвэрлүүлэгч, тээврийн агентуудын ашиг сонирхол зэрэг олон хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай байдаг. Харин ачааг буудалд зөөж хүргэх, хадгалах, даатгуулах, гаалийн бүрдүүлэлт хийхтэй холбоотой зардлууд үүнд хамаардаггүй.

Олон улсын агаарын ачаа тээвэрлэх тарифыг тооцож буй аргаар нь гурван төрөлд хувааж үздэг. Үүнд:

- Үндсэн тариф
- Ангилалын
- Тусгай

Үндсэн тариф

Үндсэн тариф бол ачилтын цэгээс буулгах цэг хүртэл 1 кг ачааг тээвэрлэхэд гарах хөлсийг тооцоход тогтоосон тариф юм.

Ангиллын тариф

Ангиллын тариф бол ачааны тодорхой ангиллуудаар тооцож авдаг тариф юм. Ачааны бүлгүүдэд ангиллын тарифыг тогтоохдоо ердийн тарифын

тодорхой хувьтай дүйцүүлэх замаар тооцож гаргадаг. Ангиллын тариф нь тээвэрлэлтийн онцгой нөхцөл шаардагдах ачааны бүлгүүдээр тогтоогддог. Жишээ нь: Амьд амьтан ургамал, үнэ цэнэтэй зүйл, шил шаазан эдлэл, тээвэрлэлтийн онцгой горим шаардах техник хэрэгсэл, эм тариа гэх мэт.

Тусгай тариф

Тусгай тариф бол хөнгөлөлтийн нөхцөлтэй тээврийн тариф юм. Түүнийг тодорхой нэр төрлийн таваарыг агаараар тээвэрлэх үед нислэгийн чиглэлийн зөвхөн нэг талд ашигладаг. Агаарын тээврийн пүүсүүд тусгай тарифыг мөрдөх таваарын нэр төрлийн жагсаалтыг гаргасан байдаг бөгөөд тэрхүү жагсаалтад байгаа бараа нь 4 оронтой кодоор илэрхийлэгдсэн байна. Дээрх кодууд дэлхийн аль ч улсад нэгэн ижил нэр төрлийн барааг илэрхийлдэг. Олон улсын практикт тусгай тарифын хөнгөлөлтийн хувь хэмжээг ердийн тарифын 40-90 %-тай тэнцэх хэмжээнд тогтоож мөрддөг.

Дэлхийн олонх агаарын тээврийн пүүсүүд зорчигч ба ачааны аль алиныг нь тээвэрлэдэг холимог хэлбэрийн тээвэрлэлт хийдэг. Агаараар ачаа тээвэрлэх үйл ажиллагааны зардалд нисэх буудлуудын үйлчилгээний хураамж нэлээд өндөр хувийг эзэлдэг байна.

Дэлхийн хамгийн том зорчигч тээврийн нисэх онгоц



Airbus S.A.S концерны бүтээсэн бүхээг нь дотроо хоёр давхар бүхий, дөрвөн тийрэлтэт хөдөлгүүртэй зорчигч тээвэрлэх Airbus A380 хөлөг онгоц дэлхийн хамгийн том хэмжээтэй нисэх онгоц билээ. Түүний өндөр 24,08 метр бол урт нь 72,75 метр юм. Далавчны урт 79,75 метр аж. Хүндийн жин нь 280 тонн бөгөөд мөн хэмжээний ачаа тээш, зорчигчдыг тээвэрлэх боломжтой. Энэ загварын хөлөг онгоц 525 зорчигчийг тээвэрлэдэг нь дараагийн томоохон өрсөлдөгч болох Boeing 747-гоос бараг 100 хүнээр илүү гэсэн үг.

Ан-225 нь урьд өмнө агаарт дүүлж байсан хамгийн хүнд жинтэй ачааны нисэх онгоц билээ. Далавчныхаа уртаар Ан-225-аас давж гарсан цорын ганц онгоц бол Hughes H-4 Hercules юм. Гэхдээ Hercules нисдэг завь ангилалд хамааралтай бөгөөд ердөө ганцхан удаа л 1947 онд газраас хөөрч байжээ. Ан-225 нисэх онгоцны өөрийнх нь жин 250 тонн бөгөөд тэрээр 640 тонн жинг агаарт хөөргөх чадвартай аж. Ер нь бол "Мрия" хөлөг онгоц тээвэрлэх ачааныхаа чадлаар олон тооны дээд амжилтын эзэн болсон гэдэг. Нийтдээ тэрээр 250 орчим удаа дэлхийн дээд амжилтыг тогтоожээ. Өдгөө энэ онгоцыг Украины агаарын тээврийн Antonov Airlines компани эзэмшиж байгаа билээ.



Дэлхийн хамгийн том ачаа тээврийн нисэх онгоц Ан-225 "Мрия"

4. Олон улсын агаарын тээвэрлэлтийн эрх зүйн зохицуулалт

Олон улсын агаарын тээвэрлэлт нь өөр өөр улс орнуудын агаарын орон зай, далай тэнгисийг дамнан хийгддэг учир олон улсын болон хоёр улсын хооронд байгуулагдсан гэрээ хэлэлцээрээр агаарын хөлгийн ба тээвэрлэж буй ачааны бүрэн бүтэн аюулгүй байдал хангагдаж байдаг.

Олон улсын агаарын ачаа тээвэрлэлтийг зохицуулах эрх зүйн гол акт бол “Агаараар ачаа тээвэрлэх зарим горим журмыг нэгдсэн хэлбэрт оруулах” тухай 1929 оны Варшавын конвенци юм.

Хэдийгээр манай улсын хувьд агаарын тээвэрлэлтийн нийт бараа эргэлтэд эзлэх хувь бага боловч төрийн бодлогоор агаарын тээврийн салбарыг анхаарч ирсэн. Дээрх конвенцид Монгол улс нэгдсэнээс гадна Монголын иргэний агаарын тээврийн байгууллага нь Олон улсын агаарын тээврийн холбоо (*IATA*), НҮБ-ын төрөлжсөн байгууллага болох Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагын (*ICAO*) гишүүн юм. Тиймээс Монгол улсаас дэлхийн аль ч улс руу агаараар ачаа тээвэрлэх боломж нээлттэй байдаг.

Монгол Улсад агаарын тээврийн салбар 1946 оноос үүсч хөгжсөн гэж үздэг. Далайд гарцгүй эх газрын орны хувьд агаарын тээвэрлэлт нь Монгол улсын тээвэрлэлтийн үндсэн нэг хэлбэр болдог. Монголд өмчийн төрөл бүрийн хэлбэрийн хэд хэдэн компаниуд агаарын тээврийн үйл ажиллагаагаа явуулж байна.



Монголын агаарын тээврийн техникийн боломж нэг удаагийн тээвэрлэлтээр зорчигчдын тээшийг оролцуулаад 15 тонн хүртэлх жинтэй, овор хэмжээ багатай ачааг хүргэх боломжтой. Өнөөгийн байдлаар ачаа тээвэрлэх

тусгай томоохон агаарын хөлөг онгоц манай улсад байхгүй байгаа нь агаарын тээврээр тээвэрлэх барааны жин, овор хэмжээг хязгаарлах нөхцөл болдог. Тиймээс овор хэмжээ, жин багатай, өндөр үнэтэй бүтээгдэхүүнийг тээвэрлэх нь ашигтай байдаг.

Агаарын тээврээр Монгол улсаас ямааны ноолуураар хийсэн бүтээгдэхүүнийг Москвагаар дамжуулан баруун Европын хэрэглэгчдэд хүргэдэг.

Европоос Оросоор дамжин агаараар тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн болон эмийн зүйлс нийлүүлж байна.

Москвагаас Улаанбаатарт нэг нислэгээр 1-10 тонн ачаа хүргэдэг ба зорчигчдын гар тээштэй нийлээд 15 тонноос хэтрэхгүй байдаг ажээ. Тиймээс Монгол улс жилдээ зорчигчийн гар тээш, шууданг оролцуулаад дунджаар 3 мянга орчим тонн барааг л агаараар тээвэрлэж байна. Хүснэгт 1-ээс Монгол улсын агаараар тээвэрлэсэн ачааны статистик үзүүлэлтийг харуулав.

Хүснэгт 1. Агаарын тээвэрлэсэн ачаа /тонн/

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Шуудан	381.2	429.1	409.1	381.1	261.5	218.3	257.3	219.8
Тээш	273.7	392.5	480.	561.7	260.6	213.1	151.9	115.4
Ачаа	988.	2,106.9	3,122.	3,132.8	2,914.7	2,408.	2,688.4	2,748.5
Нийт	1,642.9	2,928.5	4,011.1	4,075.6	3,436.7	2,839.4	3,097.6	3,083.7

Эх үүсвэр: Үндэсний статистикийн газар, <http://1212.mn>

Хэдийгээр агаараар тээвэрлэж буй ачааны хэмжээ бага байгаа боловч цаашид өсөх магадлал өндөр байна. Учир нь агаараар тээвэрлэх боломжит экспорт/импортын барааны хэмжээ олон улсын нислэгийн тооноос хамаарна. Нислэгийн тоо (Хүснэгт 2) нэмэгдэх тусам нэмүү өртөг шинэгсэн дотооддоо үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг агаарын тээврээр тээвэрлэх боломж нэмэгдэх юм.

Хүснэгт 2. Олон улсын нислэгийн тоо

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Олон улсын нислэгийн тоо	5048	6101	6353	6696	6723	6430	6726	7921

Эх үүсвэр: Үндэсний статистикийн газар, <http://1212.mn>

Хүснэгт 2-оос харахад олон улсын нислэгийн тоо сүүлийн жилүүдэд байнга нэмэгдэж байгааг харж болохоор байна. Тиймээс манай экспортлогчдод илүү их боломж гарна. Гэхдээ энэ төрлийн тээврийн хэрэгслийг сонгохоор бол таны үйлдвэрлэсэн бараа үнэтэй бөгөөд овор хэмжээ багатай байх ёстой. Тухайлбал үнэт металл, гоёл чимэглэл гэх мэт.

Монгол улсын нутаг дэвсгэрээс дараах агаарын тээврийн компаниуд гадаадын хотууд руу шууд нислэг хийж үйлдэж байна. Үүнд:

МИАТ –Монголын иргэний агаарын тээвэр

- Улаанбаатар-Бээжин
- Улаанбаатар-Токио
- Улаанбаатар-Сөүл
- Улаанбаатар- Бусан
 - Улаанбаатар-Москва
 - Улаанбаатар-Берлин
 - Улаанбаатар- Франкфурт
 - Улаанбаатар-Хонгконг
 - Улаанбаатар-Бангкок

ХҮННҮ ЭЙР

- Улаанбаатар- Эрээн
- Улаанбаатар- Бугат
- Улаанбаатар-Манжуур
- Улаанбаатар- Улаан-Үүд

АЕРО МОНГОЛИА

- Улаанбаатар-Эрхүү
- Улаанбаатар-Хөх хот

КОРЭЙН ЭЙР

- Улаанбаатар-Сөүл

ЭЙР ЧАЙНА

- Улаанбаатар-Бээжин

ТУРКИШ ЭЙРЛАЙН

- Улаанбаатар-Истанбул

АЕРОФЛОТ

- Улаанбаатар-Москва



Экспортлогч та эдгээр хотууд руу бараагаа шууд хүргүүлэхээс гадна агаарын тээврийн олон улсын гэрээний дагуу аль ч улсад агаарын тээврээр бараагаа хүргүүлэх боломжтой.

Ашигласан эх сурвалж

1. Батнасан.Н., (2003), “Гадаад худалдаа: Үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт”, хуудас 212-220
2. <http://mn.asianway.mn>
3. <https://www.mlw.mn/services/airway.php>
4. <https://www.slideshare.net/grane09/10-19032061>